



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хишигдэмбэрэлийн ТЭМҮҮЖИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-60, Факс: 32-70-16
E-mail: temuujin@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.11.20 № 411-03/13344
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан дагах хуулийн төслийг Улсын Их хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд болон Улсын Их Хурлын гишүүд санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН

Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

00000125

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

 2025.11.20 Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Ж.БАТСУУРЬ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

00000125

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРМАА

Э.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ

М.ГАНХҮЛЭГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

A large, stylized handwritten signature in black ink is positioned to the left of the list of names. Below the signature is a small, rectangular stamp or seal, also in black ink, which appears to contain some illegible text or a logo.

00000125

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ



Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ



Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР



Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН



Т.МӨНХСАЙХАН

Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

00000125

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР



Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР



Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД



Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТУЛГА

00000125



Б.ТҮВШИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Б.УЯНГА



Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА



Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

ДАВ.ЦОГБААТАР

ДАМ.ЦОГБААТАР



О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР


Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА

Д.ЭНХТҮВШИН

00000125

A handwritten signature in black ink, featuring a stylized, looped design with a long, sweeping horizontal stroke extending to the left.

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хишигдэмбэрэлийн ТЭМҮҮЖИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-60, Факс: 32-70-16
E-mail: temuujin@parliament.mn
<http://www.parliament.mn>

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

2025.11.18 № ЧУХ-03/13182
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай

Улсын Их хурлын гишүүн Х.Тэмүүжин миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан дагах хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав.

Хавсралт 12 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН

00000122

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ТЭМҮҮЖИН

2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл:

Өнөө цагт парламентын спикер төвч, голч байр сууринаас парламентын хуралдааныг удирдах нь парламентын ардчилал, парламентын дархлааны салшгүй гол зарчим болсон байна. Учир нь парламентын нийтийн танхимыг олон намын төлөөлөл (олон ургалч байдал) бүхий чөлөөт хэлэлцүүлгийн орчин, олонх цөөнхийн бодлогын мэтгэлцээний талбар, улс төрийн зөвшил ойлголцлын механизмаас гадна, нээлттэй, хяналттай төрийн үйл ажиллагаа, иргэний мэдэх эрхийн гол эх үүсвэр байлгах нь парламентын спикер, түүнд тавигдах шаардлага, түүний томилгоо, чөлөөлөлттэй шууд холбоотой байна.

2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоотой болсон төдийгүй парламентын давжаа байдлыг засаж 126 гишүүнтэй болсон. Үүний үр дүнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар Улсын Их Хуралд 4 нам, 1 эвсэл суудал авч олон намаас бүрдсэн Улсын Их Хурал олонх цөөнхийн байр сууриас намын лидерүүд нь мэтгэлцэж, зөвшилцдөг парламентын ардчиллын тулгуур зарчим Монгол Улсад төлөвшиж, хөгжих боломж нэмэгджээ.

2025 оны 7 дугаар 9-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн өөрчлөлтөөр Улсын Их Хурал асуулгын цагтай болж Ерөнхий сайд, сөрөг хүчний лидер бодлогын мэтгэлцээн хийдэг, гишүүд цаг үеийн асуудлаар Ерөнхий сайдаас шууд асууж, хариулт авдаг улс төрийн шинэ соёл бий болсон билээ.

Монгол Улсын Үндсэн хууль 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ" гэж заасан. Намаасаа түдгэлздэг Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг аль нэг намын дарга хэрэгжүүлж болох үүдийг нээлттэй байлгах нь Үндсэн хуулийн зарчим, дэг журмыг эрсдэлд оруулах урьдач нөхцөл болно.

Мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын

Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулах тухай шинэ зохицуулалт, парламентын хяналтын шинэ механизм бий болгосон. Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт ээлжит чуулганы хугацаанд хоёр хүртэл хянан шалгах түр хороо ажиллахаар зохицуулж хэт механик хязгаарлалт бий болгосон нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг хязгаарлаж, доголдуулсан зохицуулалт болсон гэж үзэх үндэстэй байна. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тэр дундаа олон нийтийг цочирдуулсан, Улсын Их Хурал хугацаа алдалгүй хянан шалгаж, тодруулах учиртай асуудлууд Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт заасан шиг хоёр хүртэл гэдэг төлөвлөгөөний дагуу нийгэмд үүсдэггүй, иргэдийн амьдрал, улс орны үйл явдал тоонд хязгаарлагддаггүй гэдгийг ойлгох учиртай.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилж байна.

Практик хэрэгцээ, шаардлага:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн одоо байгаа зохицуулалтаар Улсын Их Хурлын даргыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар сонгосонд тооцно гэвэл 33 гишүүний саналаар сонгогдох боломжтой буюу Улсын Их Хурлын нийт гишүүдийн 1/4 гарангийн дэмжлэгтэй Улсын Их Хурлын даргатай болж болох нөхцөл байна.

Улсын Их Хурлын даргын давхар ажил эрхлэхтэй холбоотой хязгаарлалтыг тодорхой болгохгүй бол парламентын ардчиллын олон улсын жишгийн дагуу парламентын спикер төвийг сахиж хуралдааныг удирдах, олонх цөөнхийн мэтгэлцээнийг хөндлөнгийн байр сууринаас явуулах, олонхийн шийдвэр гаргах, цөөнхийн хяналт тавих эрхийг баталгаажуулах болон олон намын үзэл баримтлал, бодлогын өрсөлдөөнийг Улсын Их Хуралд хэрэгжүүлэх явдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт ээлжит чуулганы хугацаанд хоёр хүртэл Хянан шалгах түр хороо ажиллахаар заасан нь парламентын хяналт шалгалтын үйл ажиллагааг доголдуулсан төдийгүй нийтийн ашиг сонирхол хөндсөн тодорхой асуудал дээр Улсын Их Хурал ажиллаж чаддаггүй, олон нийтийн дуу хоолойг сонсдоггүй, нийтийн төлөө санаа тавих хүсэл зориггүй, Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй гэж иргэд олон нийт үнэлэх дүгнэх үр дагавартай байх тул үүнийг засах, өөрчлөх зайлшгүй практик шаардлага гарч байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хурлын нийт бүрэлдэхүүний олонхид хүлээн зөвшөөрөгдөх, төвийг сахисан байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын хуралдааныг сонирхолын зөрчилгүй, намчирхалгүй удирдах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн түр эзгүйд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Үндсэн хуулийн шаардлага нөхцлийг ханган хэрэгжүүлэх зэрэг асуудлыг зохицуулах хуулийн зүйн үндэсийг бий болгох төдийгүй нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой

асуудлаар хянан шалгах ажлыг үр нөлөөтэй, зүй бус хязгаарлалтгүй хэрэгжүүлэх боломжийг олгоход чиглэнэ.

Хуулийн төсөл нь гурван зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Улсын Их Хурлын даргыг сонгох гэсэн 11 дүгээр зүйлийг өөрчлөн найруулсан, 2 дугаар зүйл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсгийг хүчингүй болгох агуулгатай болно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсад парламентын ардчилал бэхжих, улс төрийн намууд хариуцлагажих, хуулийн биелэлт, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлэх хууль зүйн боломж нээгдэнэ.

Хуулийн төслөөр гурав ба түүнээс дээш хяналт шалгалтын түр хороо байгуулагдах хууль зүйн боломжийг нээж байгаа учир Түр хорооны дотоод зохион байгуулалттай холбогдон гарах зардлыг Түр хороонд орсон гишүүдийн төсвөөс санхүүжүүлэх талаарх зохицуулалтыг уялдуулан боловсрууллаа.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2-т “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэсэнд нийцнэ.

Хуулийн төслийн дагуу үүсэж болох үр дагавартай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

---oOo---

ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай төслийн талаар*

Өнөө цагт парламентын спикер төвч, голч байр сууринаас парламентын хуралдааныг удирдах нь парламентын ардчилал, парламентын дархлааны салшгүй гол зарчим болсон байна. Учир нь парламентын нийтийн танхимыг олон намын төлөөлөл (олон ургалч байдал) бүхий чөлөөт хэлэлцүүлгийн орчин, олонх цөөнхийн бодлогын мэтгэлцээний талбар, улс төрийн зөвшил ойлголцлын механизмаас гадна, нээлттэй, хяналттай төрийн үйл ажиллагаа, иргэний мэдэх эрхийн гол эх үүсвэр байлгах нь парламентын спикер, түүнд тавигдах шаардлага, түүний томилгоо, чөлөөлөлттэй шууд холбоотой байна.

2023 оны тавдугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоотой болсон төдийгүй парламентын давжаа байдлыг засаж 126 гишүүнтэй болсон. Үүний үр дүнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар Улсын Их Хуралд 4 нам, 1 эвсэл суудал авч олон намаас бүрдсэн Улсын Их Хурал олонх цөөнхийн байр сууриас намын лидерүүд нь мэтгэлцэж, зөвшилцдөг парламентын ардчиллын тулгуур зарчим Монгол Улсад төлөвшиж, хөгжих боломж нэмэгджээ.

2025 оны долдугаар 9-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн өөрчлөлтөөр Улсын Их Хурал асуулгын цагтай болж Ерөнхий сайд, сөрөг хүчний лидер бодлогын мэтгэлцээн хийдэг, гишүүд цаг үеийн асуудлаар Ерөнхий сайдаас шууд асууж, хариулт авдаг улс төрийн шинэ соёл бий болсон билээ.

Улсын Их Хурлын даргын давхар ажил эрхлэхтэй холбоотой хязгаарлалтыг тодорхой болгохгүй бол парламентын ардчиллын олон улсын жишгийн дагуу парламентын спикер төвийг сахиж хуралдааныг удирдах, олонх цөөнхийн мэтгэлцээнийг хөндлөнгийн байр сууринаас явуулах, олонхийн шийдвэр гаргах, цөөнхийн хяналт тавих эрхийг баталгаажуулах болон олон намын үзэл баримтлал, бодлогын өрсөлдөөнийг Улсын Их Хуралд хэрэгжүүлэх явдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулах тухай шинэ зохицуулалт, парламентын хяналтын шинэ механизм бий болгосон.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт ээлжит чуулганы хугацаанд хоёр хүртэл Хянан шалгах түр хороо ажиллахаар заасан нь парламентын хяналт шалгалтын үйл ажиллагааг доголдуулсан төдийгүй нийтийн ашиг сонирхол хөндсөн тодорхой асуудал дээр Улсын Их Хурал ажиллаж чаддаггүй, олон нийтийн дуу хоолойг сонсдоггүй, нийтийн төлөө санаа тавих хүсэл зориггүй, Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй гэж иргэд олон нийт үнэлэх дүгнэх үр дагавартай байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилсан болно.

Хуулийн төсөл нь гурван зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Улсын Их Хурлын даргыг сонгох гэсэн 11 дүгээр зүйлийг өөрчлөн найруулсан, 2 дугаар зүйл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсгийг хүчингүй болгох агуулгатай болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсад парламентын ардчилал бэхжих, улс төрийн намууд хариуцлагажих, хуулийн биелэлт, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлэх хууль зүйн боломж нээгдэнэ.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай төслийн талаар*

Өнөө цагт парламентын спикер төвч, голч байр сууринаас парламентын хуралдааныг удирдах нь парламентын ардчилал, парламентын дархлааны салшгүй гол зарчим болсон байна. Учир нь парламентын нийтийн танхимыг олон намын төлөөлөл (олон ургалч байдал) бүхий чөлөөт хэлэлцүүлгийн орчин, олонх цөөнхийн бодлогын мэтгэлцээний талбар, улс төрийн зөвшил ойлголцлын механизмаас гадна, нээлттэй, хяналттай төрийн үйл ажиллагаа, иргэний мэдэх эрхийн гол эх үүсвэр байлгах нь парламентын спикер, түүнд тавигдах шаардлага, түүний томилгоо, чөлөөлөлттэй шууд холбоотой байна.

2023 оны тавдугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоотой болсон төдийгүй парламентын давжаа байдлыг засаж 126 гишүүнтэй болсон. Үүний үр дүнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар Улсын Их Хуралд 4 нам, 1 эвсэл суудал авч олон намаас бүрдсэн Улсын Их Хурал олонх цөөнхийн байр сууриас намын лидерүүд нь мэтгэлцэж, зөвшилцдөг парламентын ардчиллын тулгуур зарчим Монгол Улсад төлөвшиж, хөгжих боломж нэмэгджээ.

2025 оны долдугаар 9-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн өөрчлөлтөөр Улсын Их Хурал асуулгын цагтай болж Ерөнхий сайд, сөрөг хүчний лидер бодлогын мэтгэлцээн хийдэг, гишүүд цаг үеийн асуудлаар Ерөнхий сайдаас шууд асууж, хариулт авдаг улс төрийн шинэ соёл бий болсон билээ.

Улсын Их Хурлын даргын давхар ажил эрхлэхтэй холбоотой хязгаарлалтыг тодорхой болгохгүй бол парламентын ардчиллын олон улсын жишгийн дагуу парламентын спикер төвийг сахиж хуралдааныг удирдах, олонх цөөнхийн мэтгэлцээнийг хөндлөнгийн байр сууринаас явуулах, олонхийн шийдвэр гаргах, цөөнхийн хяналт тавих эрхийг баталгаажуулах болон олон намын үзэл баримтлал, бодлогын өрсөлдөөнийг Улсын Их Хуралд хэрэгжүүлэх явдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулах тухай шинэ зохицуулалт, парламентын хяналтын шинэ механизм бий болгосон.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт ээлжит чуулганы хугацаанд хоёр хүртэл Хянан шалгах түр хороо ажиллахаар заасан нь парламентын хяналт шалгалтын үйл ажиллагааг доголдуулсан төдийгүй нийтийн ашиг сонирхол хөндсөн тодорхой асуудал дээр Улсын Их Хурал ажиллаж чаддаггүй, олон нийтийн дуу хоолойг сонсдоггүй, нийтийн төлөө санаа тавих хүсэл зориггүй, Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй гэж иргэд олон нийт үнэлэх дүгнэх үр дагавартай байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилсан болно.

Хуулийн төслийн зорилго нь Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хурлын нийт бүрэлдэхүүний олонхид хүлээн зөвшөөрөгдөх, төвийг сахисан байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын хуралдааныг сонирхолын зөрчилгүй, намчирхалгүй удирдах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн түр эзгүйд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Үндсэн хуулийн шаардлага нөхцлийг ханган хэрэгжүүлэх зэрэг асуудлыг зохицуулах хууль зүйн үндсийг бий болгох төдийгүй нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах ажлыг үр нөлөөтэй, зүй бус хязгаарлалтгүй хэрэгжүүлэх боломжийг олгоход чиглэнэ.

Хуулийн төсөл нь гурван зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Улсын Их Хурлын даргыг сонгох гэсэн 11 дүгээр зүйлийг өөрчлөн найруулсан, 2 дугаар зүйл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсгийг хүчингүй болгох агуулгатай болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсад парламентын ардчилал бэхжих, улс төрийн намууд хариуцлагажих, хуулийн биелэлт, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлэх хууль зүйн боломж нээгдэнэ.

Хуулийн төслөөр гурав ба түүнээс дээш Хяналт шалгалтын түр хороо байгуулагдах хууль зүйн боломжийг нээж байгаа учир Түр хорооны дотоод зохион байгуулалттай холбогдон гарах зардлыг Түр хороонд орсон гишүүдийн төсвөөс санхүүжүүлэх талаарх зохицуулалтыг уялдуулан боловсрууллаа.

Хуулийн төслийн дагуу үүсэж болох үр дагавартай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргыг сонгох

11.1. Олонх Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ.

11.2. Улсын Их Хурлын даргыг гишүүн саналаа илээр гаргаж, нийт гишүүдийн олонхын саналаар дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.

11.3. Нэр дэвшигч Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй бол энэ хуулийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу өөр гишүүний нэрийг дэвшүүлж сонгоно.

11.4. Улсын Их Хурлын дарга нь намуудын улс төрөөс ангид бие даасан, төвийг сахисан байр сууринаас бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Улсын Их Хурлын дарга Олон Улсын Парламентын Холбоо хоорондын тохиролцсон албан тушаалаас өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.

11.5. Улсын Их Хурлын дарга бүрэн эрхийнхээ хугацаанд намаасаа түдгэлзэнэ. Улсын Их Хурлын дарга намаасаа түдгэлзсэн нь түүний Улсын Их Хурлын дараагийн ээлжит болон ээлжит бус сонгуульд намаасаа нэр дэвших эрхийг хязгаарлахгүй.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“56.1.Түр хорооны дотоод зохион байгуулалттай холбогдон гарах зардлыг түр хороонд орсон гишүүдийн төсөвөөс санхүүжүүлэх бөгөөд Түр хорооны тусгай шалгах үйл ажиллагаатай холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/19 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргыг сонгох

“19.1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу олонх Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ.

19.2. Улсын Их Хурлын даргыг сонгоход гишүүд асуулт асууж, үг хэлэх бөгөөд ил санал хураалт явуулж, нийт гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.

19.3. Нэр дэвшигч нийт гишүүдийн олонхын дэмжлэг аваагүй бол энэ хуулийн 19.1-т заасны дагуу өөр гишүүний нэрийг дэвшүүлж сонгоно.”

2/88 дугаар зүйл. Цэцэд хүсэлт гаргах

“88.1. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар Улсын Их Хурлаас Цэцэд хүсэлт гаргах саналыг албан ёсоор тавибал уг саналыг ажлын 14 өдрийн дотор чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж сонсгоно.

88.2. Энэ хуулийн 88.1-д зааснаас бусад Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар гишүүн Улсын Их Хурлаас Цэцэд хүсэлт гаргах саналыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг Хууль зүйн байнгын хороо ажлын 14 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж саналд дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ оруулна.

88.3. Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 88.2-т заасан санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор хуралдаж асуудал нэг бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулах бөгөөд санал хураалтаар олонхын дэмжлэг авсан маргаантай асуудлаар Цэцэд хүсэлт гаргахыг зөвшөөрсөн гэж үзнэ.

88.4.Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 88.1, 88.3-т заасан маргаантай асуудлаар хүсэлт гаргах тухай албан бичгийг Цэцэд хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар

сарын ...-ны өдөр

Улаанбаатар

хот

НАМЫН ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗВЭЛ ЗОХИХ АЛБАН ТУШААЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуулийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх бүхий заалт нэмсүгэй:

“9/Улсын Их Хурлын дарга.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг